



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/798

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Токиогийн олимпын хүрэл медаль хүртсэн Б.Болортуяад батламж хийлгэсэн зардалд 65 000 төгрөг, Гавьяат багш цол хүртсэн Цаст-Алтай цогцолбор сургуулийн багш Х.Цэрмаад 270 000 төгрөг, Хос ган үзэгтэн шагнал хүртсэн Н.Таванцэцэгт өргөмжлөл хийлгэсэн зардалд 85 000 төгрөг, мөнгөн шагналд 250 000 төгрөг, Ховд аймгийн Цагдаагийн газрын даргын ажил хүлээлцсэн бүрэлдэхүүнтэй хийсэн уулзалтын зардалд 336 000 төгрөг, Тахилга, тайлга зохион байгуулах талаар Егүзэр хутагт Данзанлуvsанванжилтай хийсэн уулзалтын арга хэмжээний зардалд 1 851 000 төгрөг, “Илгээлт-2100” арга хэмжээ зохион байгуулахтай холбоотой гарсан зардалд 155 800 төгрөг, Аймгийн хөрөнгө оруулалт, төсвийг нэмэгдүүлэх чиглэлээр Засаг дарга Улаанбаатар хотод ажилласан зардалд 1 303 300 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 980 100 төгрөг /Гурван сая есөн зуун наян мянга нэг зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/798-Bo